



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/145

Мандалговь

“Дуу хуурын өлгий-Дундговь нутаг”  
дэлгэцийн бүтээлд хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн онцлог, өв соёл, зан заншил, байгалийн үзэсгэлэн, өнөөдрийн өнгө төрх, ажил үйлс, хөгжил дэвшлийг дэлгэцэд мөнхлөн үлдээх, гадаад дотоодод сурталчлан таниулах зорилгоор “Дуу хуурын өлгий-Дундговь нутаг” дэлгэцийн бүтээлийг “Монгал Эф Пи” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. “Дуу хуурын өлгий-Дундговь нутаг” дэлгэцийн бүтээлийн зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. “Дуу хуурын өлгий-Дундговь нутаг” дэлгэцийн бүтээл гүйцэтгэж байгаа “Монгал Эф Пи” ХХК-тай гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, тус уран бүтээлийг хугацаандаа хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Дээрх арга хэмжээнд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ

482010407

Аймгийн Засаг даргын 2020 оны  
05 дугаар сарын 28-ны өдрийн А/Д/5 дугаар  
захирамжийн хавсралт

“ДУУ ХУУРЫН ӨЛГИЙ-ДУНДГОВЬ НУТАГ”  
ДЭЛГЭЦИЙН БҮТЭЭЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зарлагын нэр	Тоо ширхэг	Үнэ	Нийт үнэ
1.	“Дуу хуурын өлгий-Дундговь нутаг” тус бүр 20 минутын хоёр бүлэг кино	1	10,000,000	10,000,000
Бүгд				10,000,000